

## АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:

Булган аймгийн  
Төрийн аудитын газар

Тэргүүлэх Аудитор

Д.Анхбаяр

Аудитын менежер

Ж.Энхцоодол

Ахлах аудитор

Г.Ганбаатар

Аудитор

Х.Баттулга

2018 оны 6 дүгээр сар

Аудитын тайлантай  
холбоотой асуудлаар  
нэмж тодруулах, асууж  
лавлах зүйл байвал  
70342495 дугаарын утас,  
70342580 дугаарын  
факсаар харилцана уу.

Цахим хаяг:  
Bulgan@audit.gov.mn

Товчилсон үгсийн жагсаалт

Аудитын зорилт, хамрах хийрэг, арга зүй

**Билэг А Дулааны станцын төсөл, арга хэмжээ үр дүнтэй хэрэгжсэн үү.**

А.1. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаа, холбогдох хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.

А.2. Дулааны станцын зураг төсвийг үндэслэлтэй боловсруулсан байна.

А.3. Гүйцэтгэгч байгууллага гэрээний үүргээ хугацаанд нь биелүүлээгүй, гэрээг дүгнэж биелэлтийг тооцоогүй, ажил удааширсан байна.

**Билэг Б Улсын төсвийн хөрөнгө оруулалт болон өөрийн хөрөнгийн үр, өгөөж үр нөлөөг үнэлсэн үү.**

Б.1. Барилга захиалагчийн тавих хяналт орон нутагт хэрэгжээгүй байна.

Б.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаж авсан зарим санхүүжилтын хувиарлалт тодорхойгүй байна.

Б.3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг зориулалтын дагуу зарцуулсан эсэх нь тодорхойгүй гүйцэтгэл байхгүй байна.

**Билэг В Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт үр ашигтай байна үү.**

В.1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын зарцуулалтын хяналт сул байна.

В.2. Дулааны станцад оруулсан санхүүжилтын бусад эх үүсвэрийн хэмжээ тодорхойгүй байна.

В.3. Орон нутагт хийгдсэн хөрөнгө оруулалтын хадаглалт хамгаалалт хангалтгүй байна.

**ДҮГНЭЛТ  
ЗӨВЛӨМЖ**

## ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

ҮАГ	Үндэсний Аудитын газар
ТАТ	Төрийн аудитын тухай хууль
ТХШТХ	Төрийн хяналт шалгалтын тухай хууль
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
НББ	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
ТТХ	Төсвийн тухай хууль
НББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НӨАТ	Нэмэгдсэн өртөгийн албан татвар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
АЗД	Аймгийн Засаг дарга
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЭХХТ	Эрчим хүчний хөгжлийн төв

## Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

2018.06.28.

Булган

### 1. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аймгийн аудитын газрын 2018 оны бүтээгдэхүүн ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

### 2. Аудитын зорилт:

Аудитын зорилт нь Дулааны станцын ажлын явц, гэрээний хэрэгжилт, үр дүн, улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын зарцуулалт, төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалтанд тавих дотоодын хяналтыг хэрхэн үр ашигтайгаар хэрэгжүүлж ямар үр нөлөөтэй ажилласанд дүгнэлт өгч шаардлагатай бол санал боловсруулж холбогдох байгууллага, албан тушаалтнаар шийдвэрлүүлэхэд оршино.

- Дулааны станцын ажлын явц үр дүн,
- Дулааны станцын гэрээний хэрэгжилт,
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын зарцуулалт, үр дүн,
- Орон нутгийн оролцоо, хөрөнгө оруулалтын явц, үр дүн,
- Төрийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт хамгаалалт,
- Холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт,

### 3. Аудитын хамрах хүрээ:

Булган аймгийн Дулааны станцын ажлын явц, гэрээний хэрэгжилт, улсын төсвийн болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр дүн, аймгийн ЗДТГ-ын хөрөнгө оруулалт хөгжлийн бодлогын хэлтсийн бодлогын хэрэгжилт, аймгийн ГХБХБГ-аас гэрээний дагуу хийсэн хяналт үр дүнг хамруулаа.

### 4. Шалгуур үзүүлэлт

- Төрийн аудитын тухай хууль
- Төрийн хяналт шалгалтын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Засгийн газрын холбогдох тогтоол шийдвэрүүд, хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан дүрэм журам
- Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн тогтоол,
- Гэрээний биелэлтийг тооцох
- Холбогдох бусад хууль, тогтоомж

## 5. Аудит хийх багийн бүрэлдэхүүн, хугацаа

Аудитыг Аймгийн төрийн аудитын газрын даргын удирдамжаар аймгийн Тэргүүлэх аудитор Д.Анхбаяр удирдаж, менежер Ж.Энхцоодол хяналт тавьж ахлах аудитор Г.Ганбаатар, аудитор Х.Баттулга нар 2018 оны 06 дугаар сарын 06-наас эхлэн ажлын 24 хоногт багтаан удирдамжийн дагуу явуулаа.

## 6. Ерөнхий мэдээлэл:

Булган аймгийн төв Булган сум нь нийт 12.6 мянган хүн амтай, 3635 өрхтэй, аймгийн төвийн төр, төсвийн, аж ахуйн нэгж, үйлчилгээний байгууллага, хувийн хэвшлийн байгууллагууд, орон сууцанд амьдарч байга айл өрхүүд дулааны эрчим хүчээр хангагдаж байна. Одоогийн байдлаар дулааны эрчим хүчийг “Булган-Мээж” ХХК хариуцан 19 уурын зуух бүхий дулааны 6 төвөөр дамжуулан хэрэглэгчдийг дулааны эрчим хүчээр хангадаг. Цаашид хэрэглэгчдийг найдвартай дулаанаар хангах, техник техинологийн шаардлага стандарт хангасан, байгаль орчинд ээлтэй, агаарын бохирдол, хорт хий, тоос ялгаруулдаггүй орчин үеийн техникийн шаардлага хангасан “Дулааны станц” барих шаардлага байгаа мөн аймгийн Засаг даргын 2008-2012 оны мөрийн хөтөлбөрт Булган сумын хэрэглэгчдийг дулаанаар найдвартай хангах зорилт дэвшүүлсэн.

Аймаг дэвшүүлсэн зорилтоо хэрэгжүүлэхийн тулд “Дулааны станц” барих ажлыг 2010 онд аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн тогтоол гарч, аймгийн засаг дарга эрх олгосноор дулааны станц барих сонгон шалгаруулалт зарлаж, Концессын тухай хуулийн 19,3 дахь заалтыг үндэслэн “Сэлэнгэ констракшн” ХХК-ийг шалгаруулж SHX-14-1,65/130-70/ маркийн хүчин чадалтай /2 тогоотой/ дулааны станцыг өөрийн хувийн хөрөнгөөр барьж 2011 онд ашиглалтанд өгөхөөр гэрээ байгуулсан боловч одоо хүртэл ашиглалтанд оруулаагүй байна.

Аймгийн Засаг даргын 2010 оны 347 дугаар захирамжаар аймгийн Шүүхийн ар талд Булган хотын дулааны станц барих зориулалтаар 7567 м/кв газрыг “Сэлэнгэ констракшн” ХХК-д эзэмшүүлсэн байна.

Төрийн аудитын газар

Дулааны станцын ажлын явц, гэрээний хэрэгжилт, үр дүн

### Бүлэг А

Дулааны станц гэрээний үүргээ биелүүлээгүй, хугацаа хэтэрсэн, хяналт сул, хангалтгүй хэрэгжиж байна.

#### А.1. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаа, холбогдох хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.

Аймгийн Засаг даргын 2008-2012 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, Булган аймгийн хөгжлийн цогц бодлого /2010-2021он/, аймгийн төвийн дулаан хэрэглэгчдийг дулааны найдвартай эх үүсвэрээр хангах зорилт тусгагдсан, уг зорилтыг хэрэгжүүлэхээр 2010 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн ИТХ-ын тэргүүлэгчдийн VII хуралдааны 07/03 тоот тогтоолоор станц байгуулахыг зөвшөөрсөн.

Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2010 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн 105 дугаар тогтоолын 1-д “Булган аймгийн төвд дулааны станцыг өөрийн хөрөнгөөр шинээр барих, ашиглалтыг хариуцах гүйцэтгэгчийг сонгох” төсөл сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн гүйцэтгэгчтэй гэрээ байгуулж ажиллахыг аймгийн Засаг дарга /М.Оюунбат/-д зөвшөөрсүгэй гэсэн шийдвэр гаргасан байна.

Энэ шийдвэрийн дагуу БУ-ДУ.СТАНЦ-01/2010 дугаартай Булган хотын дулааны станцыг өөрийн хөрөнгөөр барьж, ашиглалтыг хариуцах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг гүйцэтгэх тухай битүүмжилсэн төсөл ирүүлэхийг эрх бүхий оролцогчид уриалсан боловч үнэлгээний хороо байгуулаагүй, тендерийн сонгон шалгаруулалт явагдаагүй байна.

Төслийн сонгон шалгаруулалтанд Улаанбаатар хотын “Сэлэнгэ констракшн” ХХК дангаар төсөл ирүүлж, хувийн хөрөнгөөр Дулааны станц барих ажлын гүйцэтгэгчээр шалгарсан. Гэтэл төслийн сонгон шалгаруулах үнэлгээний хороо байгуулаагүй ТБОНӨХБАҮХАТ хуулийн 47.1 дэх заалтыг зөрчсөн байна.

Орон нутгийн төсвийн 2017 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд ус, дулаан дамжуулах төвийн 3 барилга барих 430.6 сая төгрөг тусгагдсаны дагуу 2016 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр аймгийн Засаг даргын А/508 тоот захирамжаар орон нутгийн өмчийн албанаас 3, АЗДТГ-с 1, иргэдийн төлөөллөөс 1 нийт 5-н хүний бүрэлдэхүүнтэй үнэлгээний хороо байгуулсан.

Үнэлгээний хороо 2016 оны 12 дугаар сарын 01-ний өдөр ус, дулаан дамжуулах төвийн 3-н ширхэг барилга барих ажлыг гурван багц тендер болгон сонгон шалгаруулалт зарлаж 2017 оны 01 сарын 02-ны 09 цаг 00 минут хүртэл хүлээн аваад 09 цаг 30 минутанд нэхээр зарыг Булган аймгийн вэб сайт, Засгийн газрын худалдан авах ажиллагааны вэб сайт, засгийн газрын цахим худалдан авалтын сайтад тавьсан байна.

Тендерийн гурван багц тус бүрийг 143.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй сонгон шалгаруулалт зарлаж 1-р багцад 10, 2-р багцад 7, 3-р багцад 8-н нийт 25 компани тендерийн материал ирүүлж 2017 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр үнэлгээний хороо тендерийн нээлтийн хурлыг хийжээ.

Тендер шалгаруулалтад тавьсан нийтлэг шалгуур үзүүлэлтүүдээр үнэлгээний хороо харьцуулалтын үнэлгээ хийхдээ хорооны зарим гишүүд ТБОНӨХБАҮХАТ хуулийн 47.2.2-т “тендерийг хянан үзэх, үнэлэх, үнэлгээний дүгнэлт гаргах...”-гэж заасны дагуу үнэлгээ маягыг дутуу бөглөж үнэлгээ хийсэн байна.

Үнэлгээний хорооны гишүүд ажил гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах хурлыг 2017 оны 01 дүгээр сарын 20-ний өдөр хуралдаж 3 дугаарын хурлын тэмдэглэлээр шаардлага хангасан, хамгийн сайн үнэлгээтэй тендерээр эмнэлэгийн уурын зуухны хашаа, шүүхийн уурын зуухны хашаанд баригдах ус, дулаан дамжуулах төвийг Улаанбаатар хотын “Дэлгэр ган” ХХК нэг барилгыг 132.6 сая төгрөгийн төсөвт өртгөөр, МСҮТ-н хашаанд баригдах төвийг “Булган барилга” ХХК 138.1 сая төгрөгийн төсөвт өртгөөр хийж гүйцэтгүүлэхээр сонгон гишүүдийн 100 хувийн саналаар дэмжиж шийдвэрлэн аймгийн Засаг даргад гэрээ байгуулах зөвлөмж хүргүүлсэн байна.

Үнэлгээний хорооны шийдвэрийг “Таслт билэг” ХХК, “Буяннэмэх-Интер” ХХК, “Гурван дэлгэр” ХХК-ууд хүлээн зөвшөөрөхгүй Сангийн яаманд гомдол гаргаж

Яамнаас 2018 оны 02 дугаар сарын 10-ны өдөр дахин үнэлгээ хийж хариу мэдэгдэх, тендерийн хугацааг 2017 оны 02 дугаар сарын 08-ны өдөр 30 хоногоор сунгажээ.

Үнэлгээний хороо Сангийн яамны шийдвэрийн дагуу дахин үнэлгээг 2017 оны 03 дугаар сарын 06-ны өдөр гишүүдийн 80 хувийн ирцтэй хуралдаж “Булган барилга” ХХК-ийг 80 хувийн саналаар, “Дэлгэр ган” ХХК-ийг 60 хувийн саналаар дэмжиж гэрээ байгуулах шийдвэр гаргасан нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 47.4-т “,,,орон нутагт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн төлөөлөгчдийн иурлаас томилсон иргэн, Засаг даргын тамгын газрын ажилтныг оролцуулна”-гэж заасны дагуу иргэдийн төлөөлөгч Д.Шийрэвжамц хуралд оролцоогүй,

Мөн хуулийн 47.3-ын “үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд орсон албан тушаалтан дараах шаардлагыг хангасан байвал зохино”, 47.3.2-т “тендерт оролцогч болон түүнийг төлөөлөх этгээдийн эцэг, эх, хадам эцэг, эх, эхнэр, нөхөр, ах, эгч, дүү, хүүхэд биш байх” гэж заасан байтал гишүүн Г.Давааням нь “Дэлгэр ган ХХК-ний захиралтай хамаарал бүхий этгээд учир санал өгөөгүй нь,

Энэ хуулийн 47.7-н “Үнэлгээний дүгнэлтэд хорооны бүх гишүүд гарын үсэг зурж баталгаажуулах бөгөөд эсрэг саналтай байсан гишүүн үнэлгээний дүгнэлтэд энэ тухайгаа тэмдэглэж гарын үсгээ зурна” гэсэн заалтуудыг зөрчсөн үнэлгээний хорооны гишүүдийн ирц муу, хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.

### **А.2. Дулааны станцын зураг төсвийг үндэслэлтэй боловсруулсан байна.**

Булган суманд дулааны станц барьж байгуулах зураг төсөв боловсруулах ажлын гэрээ, мөн Булган хотын дулааны гол шугамын зураг төсөв боловсруулах ажлын гэрээг 2010 оны 06 дугаар сарын 03-ны өдөр аймгийн Засаг дарга М.Оюунбат, “Хоризонт сервис” ХХК захирал Ц.Рэнцэндорж нар байгуулсан байна.

Дулааны станц, нэгдсэн гурван халаалтын зуухыг станцтай холбох дулааны шугам сүлжээний ажлын зураг төслийг Улаанбаатар хотын “Хоризонт сервис” ХХК гүйцэтгэсэн, зураг төсвийн үнэнд 599928.5 мянган төгрөг санхүүжүүлсэн, зураг төсвийн үнэ харцангуй өндөр өртөгтэй хийгдсэн зургийн дагуу ажил хийгдэж байна.

Анхны зураг төсөвт өөрчлөлт ороогүй, харин дулаан дамжуулах төвийн барилгын зураг төслийн ажлыг тусдана “Инж-Кад” ХХК хийж гүйцэтгэсэн байна.

### **А.3. Гүйцэтгэгч байгууллага гэрээний үүргээ хугацаанд нь биелүүлээгүй, гэрээг дүгнэж биелэлтийг тооцоогүй, ажил удааширсан байна.**

Дулааны станцыг Булган суманд барих хэрэгцээ шаардлага, Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хангах хүрээнд 2010 оны 09 дугаар сарын 10-ны өдрийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хуралдааны 105 дугаар тогтоолоор Булган аймгийн төвд дулааны станцыг өөрийн хөрөнгөөр шинээр барих, ашиглалтыг хариуцах гүйцэтгэгчийг сонгох төсөл сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн гүйцэтгэгчтэй гэрээ байгуулж ажиллахыг аймгийн Засаг дарга М.Оюунбат-д зөвшөөрсөн байна.

Энэ шийдвэрийн дагуу Монгол улсын иргэний хууль, Эрчим хүчний тухай хуулийг үндэслэн Булган аймгийн төвд дулааны станц барьж байгуулах, ажлын гэрээг 2011 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 01/2010 тоот гэрээг Булган аймгийн засаг дарга М.Оюунбат, “Сэлэнгэ констракшн” ХХК-ийн захирал Ч.Гантулга нар хэрэглэгчдийг халаалт дулаан, **хэрэглээний халуун усаар хангах** анхны гэрээг байгуулсан байна.

Булган аймгийн Булган хотын дулааны станц барих ажлыг гүйцэтгэх гэрээг 2011 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 01/2011 тоот гэрээг аймгийн Засаг дарга М.Оюунбат баталж, дулааны станцын барилга угсралтын ажлыг 2011 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн 2011 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр барилгын ажлыг бүрэн дуусгаж ашиглалтанд оруулна, барилгын нийт төсөвт өртөг 3500.0 сая төгрөг “Сэлэнгэ констракшн” ХХК өөрийн хөрөнгөөр хийж гүйцэтгэн ашиглалтанд оруулна зэрэг нөхцөлтэйгөөр гэрээ байгуулж захиалагчийг төлөөлж Булган аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга Д.Цэрэндорж гүйцэтгэгчийг төлөөлж “Сэлэнгэ констракшн” ХХК-ны захирал Ч.Гантулга нар гэрээ байгуулсан байна. Анхны гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, дулааны станцын барилга угсралтын ажлыг гэрээнд заасан хугацаанд хийж гүйцэтгээгүй, ямар ажил хийсэн нь тодорхойгүй, гэрээний биелэлтийг дүгнээгүй ажил зохиссон байна.

**Дараагийн 2 дахь гэрээг** Засгийн газрын 2014 оны “Зарим аймгийн дулаан хангамжийг сайжруулах төслийг эрчимжүүлэх тухай” 29 дүгээр тогтоол, мөн 2014 оны “Булганы дулааны станцын талаар авах зарим арга хэмжээний тухай” 257 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Эрчим хүчний яам, Эрчим хүчний зохицуулах хороо, аймгийн Засаг дарга нар нөгөө талаас “Энержи плас” ХХК-тай гэрээний нөхцлийг харилцан тохиролцож Булган аймгийн төвд шинээр дулааны станц барих төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд барих-ашиглах-өмчлөх нөхцөлтэй хамтын ажиллагааны гэрээ шинээр байгуулсан байна.

Уг гэрээг 2014 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр нэг талаас Монгол улсын эрчим хүчний сайд М.Сономпил, Эрчим хүчний зохицуулах хорооны дарга С.Отгонбаяр, Булган аймгийн Засаг дарга Д.Эрдэнэбат нар, нөгөө талаас түншийг төлөөлж “Энержи плас” ХХК-ийн захирал Ч.Гантулга нар хамтын гэрээ байгуулсан боловч дулааны станц барих төр, хувийн хэвшлийн хамтын гэрээний биелэлт хангалтгүй хэрэгжсэн байна.

Гүйцэтгэгч түнш гэрээний 5.12-д “Төслийн эхний ээлжийг 2014 оны 12 дугаар сард, дулааны станцыг 2015-2016 оны халаалтын улирал эхлэхээс өмнө бүрэн ашиглалтанд оруулна, өөрийн буруутай үйл ажиллагаа, санхүүжилт саатсан зэрэг шалтгаанаар төслийг хугацаанд оруулаагүйгээс үүсэх **эрсдлийг бүрэн хүлээнэ**”, 15.1 “Энэ гэрээ болон дагалдах бусад гэрээний нөхцөлийг хэрэгжүүлэхтэй холбоотой, гэрээнд тусгагдаагүй аливаа зардлыг талууд өөрөөр тохиролцоогүй бол өөрсдөө хариуцна”, гэсэн заалтууд хангалтгүй хэрэгжсэн, түнш гэрээний дагуу дулааны станцыг барьж байгуулах ажлыг **хугацаанд нь** хийж гүйцэтгээгүй, гэрээгээр хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн байна.

Захиалагч гэрээгээр хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлж гэрээний 3.7 “Дулааны станцын барилга угсралтын ажилд чанарын хяналт тавих, хэрхэн яаж гүйцэтгэсэн талаар шаардах эрхтэй”, 3.8.5 “Гэрээний биелэлтэд хяналт тавих зорилгоор өөрийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийг Захиалагчийн хяналтын гэрээний дагуу томилон ажиллуулах”, 3.8.6 “Төсвөөс санхүүжигдэх 3.0 тэрбум төгрөгийг Дулааны станцыг барьж дуусахад зориулан түншид зориулалтын дагуу олгуулах, түншээс төслийг хэрэгжүүлэхэд зориулан ашиглаж буй аливаа тоног төхөөрөмжийг Дулааны станцыг ашиглалтанд орох хүртэл хугацаанд барьцаалах” гэсэн заалтууд хэрэгжээгүй, 2 тал гэрээгээр хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн байна.

Засгийн газрын 2017 оны 258 дугаар тогтоол, Эрчим хүчний сайдын 2017 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 09 дүгээр тушаалыг үндэслэн Булган аймгийн Засаг дарга З.Батзориг /захиалагч/, нөгөө тал Эрчим хүчний хөгжлийн төвийн захирал Ч.Саранжав /захиалагчийн хяналт/, мөн “Энержи плас” ХХК нарын хооронд байгуулсан дулааны станц барих төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны **дараагийн 3 дахь гэрээг** 2017 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр шинээр байгуулсан байна.

Гэрээний 1.2 “Гэрээний дүн 800.0 сая төгрөг бөгөөд дулааны станцыг ажиллагаанд залгаснаар гэрээний хугацаа дуусгавар болно” гэсэн нь гэрээнд барьж дуусгах хугацааг тодорхой заагаагүй байна. Мөн 2.2 “Захиалагч нь ажлын явцад Эрчим хүчний хөгжлийн төв Булган аймгийн Газрын харилцаа, Барилга хот байгуулалтын газраар дамжуулан мэргэжлийн хяналт тавина”, Эрчим хүчний хөгжлийн төв гэрээний 3.1 “Дулааны станцыг ажиллагаанд залгахад тавих техникийн хяналтыг гүйцэтгэгчийн хийж батлуулсан ажил гүйцэтгэх үе шатны графикийн дагуу зохих мэргэжлийн баг бүрэлдэхүүнийг тухай бүр томилон ажиллуулна” 4.2 “гүйцэтгэгч нь өөрийн буруутай үйл ажиллагаанаас дулааны станцыг гэрээт хугацаанд нь залгалт хийгээгүйгээс үүсэх эрсдэлийг бүрэн хариуцана” гэсэн заалтууд бүрэн хэрэгжээгүй байна. Дулааны станцын гэрээг 3 удаа байгуулсан боловч гэрээ хангалтгүй хэрэгжсэн, ажил дуусаагүй, хариуцлага тооцоогүй, барилга угсралтын ажилд тавих хяналт сул байна.

Төрийн аудитын газар

Дулааны станцын ажлын явц, гэрээний хэрэгжилт, үр дүн

## Бүлэг Б

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн барилга байгууламжийн ажлын захиалагийн хяналт сул гүйцэтгэл тодорхойгүй, үр дүн муутай байна.

### Б.1. Барилга захиалагчийн тавих хяналт орон нутагт хэрэгжээгүй байна.

Булган аймгийн төвд дулааны станц барьж байгуулах 2011 оны 01/2010 тоот ажлын гэрээнд барилгын ажлын захиалагчийн хяналтыг аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар хяналт тавихаар шийдвэрлэгдсэн байна.

Гэтэл албан ёсоор захиалагчийн техникийн хяналтыг хэрэгжүүлээгүй, компани өөрийн хөрөнгөөр угсралтыг гүйцэтгэж байгаа, өөрсдөө хяналтыг хэрэгжүүлэх мэргэжлийн компанийг ажиллуулаж байгаа гэсэн үндэслэлээр захиалагчийн хяналтыг хийгээгүй, гэрээний үүргээ биелүүлээгүй байна.

Уг компани 2011-2014 онд дулааны станцын нүүрс хүлээн авагч, нүүрс хүлээн авагч, нүүрс бутлан ялгах цехийн барилгын каркас, халаалтын тогооны суурь болон халаалтын тогооны үндсэн угсралтын ажлыг гүйцэтгэхдээ алба ёсны барилга захиалагчийн хяналтын ажил хийгдээгүй байна.

Аймгийн ГХБХБГазраас хяналт хийсэн компани мэдээлэл, ажлын тайлан байхгүй орон нутагт барилга захиалагчийн хяналт хангалтгүй хэрэгжсэн байна.

Дулааны станц барих гэрээг 2014 онд шинэчлэн баталж барилга захиалагчийн хяналтыг Эрчим хүчний хөгжлийн төв хийхээр 084/2014 тоот гэрээ байгуулсан байна.



Гэрээнд гүйцэтгэгч техник хяналтын зардлыг 3.0 тэрбум хүртэл 1 хувиар төлөхөөр тооцож улиралд 1 удаа мэргэжлийн баг хяналт тавихаар тусгасан байна.

Эрчим хүчний хөгжлийн төв техникийн хяналт тавихдаа магадлангаар орж батлагдсан зураг төслийн дагуу техникийн шаардлага, хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа стандарт норм дүрэм нормативийн баримт бичигт тусгасан шаардлагын дагуу орон нутагт ирж захиалагчийн хяналтыг хийж 2017 оны 2а/888, 2а/982 тоот албан бичгүүдийг аймгийн ЗДТГ хүргүүлж зайлшгүй хийх, дутуу чанаргүй хийгдсэн ажлын жагсаалтын гүйцэтгэлийг яаралтай хангуулахаар ирүүлсэн байна. Аймгийн ХОХБТ-ийн хэлтэс ямар нэгэн арга хэмжээ аваагүй, гүйцэтгэлийн тайлан тооцоо байхгүй байна.

Барилгын тухай хуулийн 35.1.2 “Барилгын үйл ажиллагаанд барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийг мөрдүүлэх”, 35.1.6 “Барилгын ажлын зөвшөөрөл олгож, барилга байгууламжийг ашиглалтанд оруулах”, гэсэн заалтууд хэрэгжээгүй, захиалагчийн хяналт орон нутагт хангалтгүй хэрэгжиж байна.

### **Б.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаж авсан зарим санхүүжилтын хувиарлалт тодорхойгүй байна.**

Дулааны станц барих төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны гэрээг үндэслэн 2014 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд 3.0 тэрбум төгрөгийг тусгуулаж батлуулсан. Барилгын ажлын гүйцэтгэлд зориулан ЭХЯамны 900030305 тоот данснаас “Энержи плас” ХХК-ний 1031100274805 тоот дансанд 2014 оны 10 сард 150.0, 11 сард 650.0, 12 сард 450.0, 12 дугаар сарын 30-нд 1714.5, нийт 2964.5 сая төгрөгний санхүүжилтийг авсан.

Мөн дахин гэрээг 2017 онд шинэчлэн гурвалсан гэрээ байгуулан аймгийн төвд баригдаж байгаа дулааны станцыг ажиллагаанд залгахтай холбогдуулан улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд 800.0 сая төгрөгийг тусгуулсан. Санхүүжилтийг ЭХЯамны төрийн сангийн 100900030305 тоот данснаас “Энержи плас” ХХК-ний 3002008434 тоот дансанд 2017 оны 12 сард 744.5 сая төгрөгийг хувиарилуулан авсан байна.

### **Б.3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг зориулалтын дагуу зарцуулсан эсэх нь тодорхойгүй гүйцэтгэл байхгүй байна.**

Дулааны станцыг анх 2011 онд 01/2011 тоот гэрээгээр дулааны станцын барилга угсралтын ажлыг бүрэн дуусгаж ашиглалтанд оруулна, барилгын нийт төсөвт өртөг 3500.0 сая төгрөг “Сэлэнгэ констракшн” ХХК өөрийн хөрөнгөөр хийж гүйцэтгэн ашиглалтанд оруулна гэсэн боловч барилга угсралтын ажлын хэдэн хувийг хийж гүйцэтгэсэн, хэдий хэмжээний хөрөнгө зарцуулсан нь тодорхойгүй гэрээний хугацаанд ашиглалтанд оруулаагүй байна. Өөрийн хөрөнгийн зарцуулалт тооцоо байхгүй байна.

2011 онд дулааны станцын нүүрс хүлээн авагч, нүүрс бутлан ялгах цехийн барилгын каркас, халаалтын тогооны суурин ажил хийгдсэн гэж тайлагнасан.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2011 онд дулааны шугамын өргөтгөл 585.0, 2012 онд цахилгаан хангамж, цахилгаан дамжуулах агаарын шугам 170.0, ЭБЭХ сайдын багцаас нэгдсэн халаалтын тогоонд суурилуулах ялтсан больер, тоног төхөөрөмжийг суурилуулахад 322.5 сая төгрөг нийт 1077.5 сая төгрөг зарцуулсан гэж тайлагнасан боловч ажлын гүйцэтгэл санхүүгийн үндсэн баримт байхгүй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 2014, 2017 оны төлөвлөгөөнд тусгагдсан хөрөнгийг гэрээний дагуу хувиарилж олгосон боловч 3.8 тэрбум төгрөгийн ажлын гүйцэтгэл тодорхойгүй, анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн баримт бичиг санхүүгийн тайлан тооцоо байхгүй удаа дараа шаардсан боловч ирүүлээгүй зөрчил илэрлээ. Нийтдээ улсын төсвөөс 4877.5 сая төгрөгний санхүүжилт авсан байна.

Дулааны станцад оруулсан өөрийн хөрөнгө болон улсын төсвийн хөрөнгө оруулалтын хөрөнгийн зарцуулалт тодорхойгүй, ажлын үр дүн, үр ашиг муу байна.

Ялангуяа дулааны станцын барилга угсралтын ажлыг өөрийн хөрөнгөөр шинээр барих анхны гэрээний дагуу хэдий хэмжээний хөрөнгө зарцуулсан нь тодорхойгүй, нотлох санхүүгийн баримт байхгүй шаардсан боловч ирүүлээгүй.

Төрийн аудитын газар

Дулааны станцын ажлын явц, гэрээний хэрэгжилт, үр дүн

## Бүлэг В

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт үр дүн муутай, төсөвт өртөг өндөртэй, эзэмшигч тодорхойгүй, хадаглалт, хамгаалалт хангалтгүй байна.

### В.1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын зарцуулалтын хяналт сул байна.

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2016 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 3 дугаар хуралдааны 03/03 тоот тогтоолоор орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын арга хэмжээнд аймгийн төвд дулаан дамжуулах төвийн 3 барилга барих ажлын төсөл, арга хэмжээнд 430.6 сая төгрөг батлагдсан байна.

Булган аймгийн Засаг даргын 2017 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн А/125 тоот гэрээ байгуулах захирамжийг үндэслэн ус, дулаан дамжуулах төвийн барилга угсралтын ажлыг “Булган барилга” ХХК нь МСҮТ-н хашаанд 138.1 сая төгрөгөөр, “Дэлгэр ган” ХХК нь Булган сумын шүүхийн хашаа, Булган сумын хүн эмнэлгийн зуухны хашаанд тус бүрийг 132.6 сая төгрөгийн төсөвт өртгөөр барих, барилгуудын зураг төслийн ажлыг 1.8 сая төгрөгөөр “Инж-Кад” ХХК хийж гүйцэтгэхээр Булган аймгийн Засаг дарга З.Батзоригтой “Булган барилга” ХХК-ны захирал С.Сэр-Од, “Дэлгэр ган” ХХК-ны захирал Н.Цэцэгтуяа, “Инж-Кад” ХХК-ны захирал Б.Оюун нар гэрээ байгуулжээ.

“Дэлгэр ган” ХХК нь 2017 оны 05 дугаар сарын 15-ны өдөр барилгын эхний санхүүжилт болох 181.2 сая төгрөг, 2017 оны 06 дугаар сарын 19-ний өдөр эцсийн санхүүжилт 74.4 сая төгрөгийг авч барилгыг 2017 оны 04 дүгээр сарын 04-ны өдрөөс эхлэн 2017 оны 06 дугаар сарын 02-ны өдөр барьж, барилга байгууламж ашиглалтад оруулах комиссын 06, 07 тоот актаар 1, 2-р дулааны төвийн барилгыг хүлээлгэн өгсөн.

“Булган барилга” ХХК нь 138.1 сая төгрөгийн санхүүжилтийг цалингийн зардалд 25.0 сая, материалын зардалд 57.9 сая, тээврийн зардалд 5.1 сая, машин механизмын зардал 7.3 сая, нэмэгдэл зардал 9.6 сая, ашиг 14.3 сая, захиалагчийн албаны зардал 2.4 сая, зураг төсвийн үнэ 0.6 сая, магадалшгүй ажлын зардал 3.6 сая, нормчлолын зардал 0.2 сая, татварт 12.1 сая төгрөгийг тус тус зарцуулахаар төсөв батлуулсан байна.

МСҮТ-ийн хашаанд баригдсан дулааны дамжуулах төвийн барилга угсралтын ажлыг хийж гүйцэтгэсэн санхүүжилтэд авсан 138.1 сая төгрөгийн гүйцэтгэлд аудит хийхэд

“Булган барилга” компанийн 5270234182 тоот дансанд 135.1 сая төгрөгийн санхүүжилт авч, барилгын ажлын гүйцэтгэлийг дансны хуулганаас үндсэн баримтаар түүж баталгаажуулахад цалингийн зардалд 5.9 сая, материалын зардалд 57.7, тээврийн зардал 16.4, машин механизмын зардалд 0.3, НӨАТ-т 1.3 сая нийт 81.6 сая төгрөгийг зарцуулж батлагдсан төсвөөс 56.5 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Ус, дулаан дамжуулах төвийн 3-н барилгын зураг төсвийн үнийг анх зах зээлийн ханшнаас хэт өндөр үнээр төсвийг хийсэн, аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэс үндсэн баримтаар санхүүжилт хийгээгүй, батлагдсан төсвийг шууд олгосон, ажлын гүйцэтгэлтэй уялдаагүй, төсвийн урсгал зардалд хяналт тавиагүй, төсвийг үр ашиггүй зарцуулсан байна.

“Дэлгэр ган” ххк нь 265.3 сая төгрөгийн санхүүжилтийг 1, 2 дугаар дулаан дамжуулах төвийн барилгад цалингийн зардалд 47.6 сая, материалын зардалд 121.6 сая, тээврийн зардалд 13.0 сая, машин механизмын зардал 15.6 сая, нэмэгдэл зардалд 18.2 сая, ашиг 32.4 сая, захиалагчийн албаны зардалд 5.0 сая, зураг төсвийн үнэ 1.2 сая, зураг төсвийн зохиогчийн хяналтын зардалд 2.4 сая нормчлолын сан 0.4 сая, татварт 24.8 сая төгрөг зарцуулахаар санхүүжилт авчээ.

Аймгийн шүүхийн уурын зуухны хашаа, Нэгдсэн эмнэлгийн уурын зуухны хашаанд баригдсан дулаан дамжуулах төвийн барилга угсралтын ажлын гүйцэтгэлд аудит хийхээр “Дэлгэр ган” ХХК-нд удаа дараа шаардсан боловч санхүүгийн баримтыг ирүүлээгүй тул аудит хийгдээгүй. Мөн төсвийг 70,30 хувиар тооцож гэрээний дагуу санхүүжилтийг бүрэн олгосон, тухай барилгын ажлын гүйцэтгэлд зарцуулсан санхүүгийн баримт байхгүй байна.

Дулаан дамжуулах төвийн барилгуудын үндсэн материал нь бетон суурь цутгаж төмөр карказ зангидан сендивчин хавтангаар хана босгон дээврийг хийж 10\*12 хэмжээтэй барилга барьсан, зах зээлийн үнээс хэт өндөр үнээр баригдсан нь, барилгын зураг төсвийг өндөр үнээр төлөвлөж, хэмнэлтгүй үр ашиггүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6.4.1. “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтын хэрэгжилт хангалтгүй байна.

## **В.2. Дулааны станцад оруулсан санхүүжилтын бусад эх үүсвэрийн хэмжээ тодорхойгүй байна.**

Дулааны станцад оруулсан өөрийн хөрөнгө болон хувь оруулсан бусад эх үүсвэрийн хөрөнгийн хэмжээ тодорхойгүй, аймгийн Төрийн аудитын газраас 2018 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 166 тоот албан бичгээр “Энержи плас” ХХК-д мэдэгдэл хүргүүлсэн, удаа дараа санхүүгийн ажилтан Мягмарсүрэнтэй 99028193 тоот утсаар шаардсан боловч санхүүгийн баримтыг ирүүлээгүй болно.

## **В.3. Орон нутагт хийгдсэн хөрөнгө оруулалтын хадаглалт хамгаалалт хангалтгүй байна.**

Булган сумын Дулааны станцын ус, дулаан дамжуулах төвийн 3 барилгын ажил хүлээлцэх аймгийн комиссыг Засгийн газрын 2012 оны 151-р тогтоолын 2-р хавсралтын 2-р заалтыг үндэслэн 11 хүний бүрэлдэхүүнтэй байгуулжээ.

Дулаан дамжуулах төвийн барилгын ажлыг барьж дуусган холбогдох мэргэжлийн байгууллагуудаар хяналт хийлгүүлж, ажил хүлээлцэх аймгийн комисст хүлээлгэн өгсөн байна.

Аймгийн комиссын 2017 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 04 тоот актаар Булган сумын МСҮТ-ийн халаалтын тогооны хашаанд баригдсан ус , дулаан дамжуулах төвийн 3-р барилгыг 2017 оны 05 дугаар сарын 20-ны өдөр, 2017 оны 06 дугаар сарын 02-ний өдрийн 06 тоот актаар Булган сумын Нэгдсэн эмнэлгийн халаалтын тогооны хашаанд баригдсан 2-р төвийг 2017 оны 06 дугаар сарын 02-ны өдөр, 2017 оны 06 дугаар сарын 02-ний өдрийн 07 тоот актаар аймгийн шүүхийн халаалтын тогооны хашаанд баригдсан 1-р төвийг 2017 оны 06 дугаар сарын 02-ны өдөр аймгийн комисс хүлээн авч дараах шийдвэрүүдийг гаргасан боловч хэрэгжээгүй байна. Үүнд:

-Ус, дулаан дамжуулах 3-н төвийн барилгын ажлыг хүлээж авах комиссын гишүүдийн хурлын тэмдэглэлээр ашиглалтанд оруулах,

-Тус барилга байгууламжуудыг зориулалтаар ашиглах боломжтой гэж үзээд ашиглалч байгууллагын мэдэлд 2017 оны 06 дугаар сарын 02-ны өдрөөс шилжүүлэх

-“Булган барилга ХХК-д: Улсын комиссын акт, холбогдох баримтуудын эх хувийг архивт, үлдэх хувийг ашиглагч байгууллагад ажлын 5 хоногийн дотор багтаан шилжүүлэх.

-Ашиглагч “Булган Мээж” ХХК-д: Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад уг барилга байгууламжийн холбогдох баримтуудыг ажлын 5 хоногийн дотор багтаан бүртгүүлэх.

-Барилга ашиглалтын дүрмийн дагуу барилга байгууламжийн хувийн хэрэгт баяжилт хийж байх.

Ажил хүлээлцэх комиссын шийдвэр, хууль журмын холбогдох заалт хэрэгжээгүй, комиссын актаар дулааны төвийн 3-н барилгыг “Булган Мээж” ХХК-д хүлээлгэн өгөхөөр шийдвэрсэн боловч одоо хүртэл хүлээлгэж өгөөгүй хөрөнгийн хадаглалт хамгаалалт, ашиглалт хангалтгүй байна.

Аймгийн орон нутгийн өмчийн газар Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн **6 дугаар зүйл. “Төрийн өмчид эд хөрөнгө олж авах”**, 6.1.6 “концессын гэрээний дагуу шинээр бий болсон эд хөрөнгө” гэсэн заалтуудыг хэрэгжүүлээгүй, аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлаар асуудлыг оруулж дулаан дамжуулах 3-н төвийн барилгыг “Булган Мээж” ХХК-д шилжүүлэх шийдвэр гаргуулах албан шаардлага бичлээ.

**Дулааны станцын ажлын явц удаан захиалагчийн ажлын уялдаа хяналт сул, орон нутагт барилга захиалагчийн хяналт хангалтгүй, дулааны станцад оруулсан өөрийн хөрөнгө бусад эх үүсвэр тодорхойгүй, нотлох баримтыг ирүүлээгүй, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 4.9 тэрбум төгрөгийн санхүүжилт хийгдсэн боловч зарцуулалт, ажлын гүйцэтгэл тодорхойгүй, санхүүгийн баримтыг албан бичгээр болон утсаар удаа дараа шаардсан боловч ирүүлээгүй зөрчлүүд аудитын явцад илэрлээ.**

#### **ДҮГНЭЛТ:**

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Дулааны станцыг барих анхны гэрээнд хэрэглэгчдийг хэрэглэгээний халуун усаар хангах талаар тусгагдсан боловч ажил хийгдээгүй,

- Дулааны станцыг барьж ашиглалтанд оруулах гэрээг 2011, 2014, 2017 онд 3 аймгийн Засаг даргыг дамжуулан байгуулсан боловч үр дүн муутай, биелэлтийг тооцоогүй, ажил дуусаагүй, хариуцлага тооцоогүй, барилга угсралтын ажилд тавих хяналт сул, гэрээний хэрэгжилт хангалтгүй байна.
- Дулааны станцын барилга угсралтын ажлыг өөрийн хөрөнгөөр шинээр барих анхны гэрээний дагуу хэдэн төгрөгний хөрөнгө зарцуулсан нь тодорхойгүй, нотлох санхүүгийн баримт байхгүй байна.
- Аймгийн ГХБХБГазраас албан ёсоор барилга захиалагчийн хяналтыг хийгээгүй, хяналт хийсэн компани мэдээлэл, ажлын тайлан байхгүй орон нутагт барилга захиалагчийн хяналт хангалтгүй хэрэгжсэн байна.
- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан дулаан дамжуулах 3 төвийн барилгын төсөвт өртөг зах зээлийн ханшаас хэт өндөр зураг төсөв хийгдсэн байна.
- дулааны төвийн 3-н барилгыг “Булган Мээж” ХХК-д хүлээлгэн өгөхөөр шийдвэрсэн боловч одоо хүртэл хүлээлгэж өгөөгүй эзэмшигч, ашиглалт, хадгалалт хамгаалалт хангалтгүй байна.

**ЗӨВЛӨМЖ:**

Аймгийн Засаг дарга З.Батзориг, ХОХБТХ-ийн дарга Буманбаяр, аймгийн ГХБХБГ-ын дарга Ү.Бямбасүрэн нарт:

- Дулааны станцын ажлыг хугацаанд ашиглалтанд оруулах талаар аймгийн ХОХБТХэлтэс, ГХБХБХэлтэст шуурхай үүрэг чиглэл өгч ажиллах,
- Барилгын захиалагчийн хяналтын тайланг авч гэрээний биелэлтийг тооцох

**МЭДЭГДЭЛ:**

Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллан 2018 оны 11 дүгээр сарын 30-ны дотор хариу ирүүлэхийг мэдэгдэе.

**ХЯНАСАН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.АНХБАЯР

МЕНЕЖЕР

Ж.ЭНХЦООДОЛ

**ТАЙЛАН БИЧСЭН:**

АХЛАХ АУДИТОР

Г.ГАНБААТАР

## ТАЙЛАН

БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР

Г.ГАНБААТАР

АУДИТОР

Х.БАТТУЛГА

ТАНИЛЦСАН:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

З.БАТЗОРИГ

АЙМГИЙН ХОХБТХ-ийн ДАРГА

Д.БУМАНБАЯР

АЙМГИЙН ГХБХБГ-ын ДАРГА

Ү.БЯМБАСҮРЭН

АЙМГИЙН ОНӨГ-ЫН ДАРГА

Ц.БАТЖАРГАЛ

